



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАНИЛЦУУЛГА ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шалгалтын зорилго:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана гэсэн заалтын хэрэгжилтийг хэрхэн хангасан байдалд үнэлгээ хийх зорилгоор Shilen gov.mn цахим сайтад тайлагнасан харьяа 26 байгууллагын мэдээлэлд хяналт-шинжилгээг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хугацаа:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан удирдаж, ахлах шинжээч Ц.Алтанхуяг хяналт тавьж, ахлах мэргэжилтэн С.Ганбат 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс ажлын 10 хоногийн хугацаанд гүйцэтгэв.

Гурав. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал:

Харьяа 26 байгууллагын 2026 оны 1 дүгээр улирлын shilen gov.mn сайтад нээлттэй мэдээлсэн 1768 мэдээллийг “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын 2.1-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж үнэллээ. Үүнд:

1. Мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг 18 талбарт
2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг 7 талбарт
3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг 29 талбарт
4. Үзүүлж байгаа үйлчилгээ талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг 6 талбарт
5. Бусад мэдээллийг ил тод, нээлттэй байдлыг 27 талбарт

Нийт 26 харьяа байгууллагын мэдээллийг 5 бүлгээр 68 талбарт давхардсан тоогоор 1768 мэдээллийг хянаж дүн шинжилгээ хийв.

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг үнэлэх 4 шалгуур үзүүлэлт:

- Мэдээллийн хүртээмжтэй байдал;
- Хугацаандаа нийтлэгдсэн байдал;
- Мэдээллийн бүрэн бүтэн байдал;
- Эх сурвалжийн тодорхой байдал.

Дөрөв. Шалгуулагч этгээд, хяналт шалгалтын объектын мэдээлэл:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа шууд 26 байгууллага. Үүнд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг -1
- Театр -6
- Музей -10
- Номын сан -2
- Эрдэм шинжилгээний хүрээлэн -2
- Хамгаалалтын захиргаа -3
- бусад -2 төсөвт байгууллага хяналт-шинжилгээд хамрагдсан.

Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн Соёл, урлагийн газар нь салбарын цахим системд нэгдээгүй шалтгаанаар уг шалгалтад хамрагдаагүй болно.

Тав. Өмнөх хийсэн хяналт шалгалтын түүх:

Харьяа байгууллагуудын нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний 2025 оны жилийн эцсийн тайлангаар хуулийн хэрэгжилтийн хувь 57 хувиар үнэлэгдсэн.

Зургаа. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал

Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор:

6.1 Мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд:

- Эрхэм зорилго
- Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт
- Тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн
- Тэргүүлэх чиглэл
- Чиг үүрэг
- Бүтэц, зохион байгуулалт
- Хаяг, байршил, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт
- Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг нээлттэй байршуулна.

Байгууллагуудын энэ бүлэгт байршуулсан мэдээллийн дундаж үнэлгээ **56.40%**-тай байна.

Соёлын өвийн үндэсний төв-88.66%, ЗГХА Соёл урлагийн газар-87.04%, Үндэсний номын сан-81.13%-иар мэдээллээ ил тод нээлттэй байршуулсан харин Чингис хааны өв соёлын хүрээлэн-9.72%, Улсын Филармони-27.70%, Хүүхэлдэй театр-24.07%-иар буюу хангалтгүй мэдээлсэн байна.

6.2 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд

- Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл
- Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам
- Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм
- Хүний нөөцийн стратеги
- Түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам
- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

- Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам-ийг нээлттэй мэдээлнэ.

Байгууллагуудын энэ бүлэгт байршуулсан мэдээллийн дундаж үнэлгээ **50.79%**-тай байна.

Соёлын өвийн үндэсний төв-93.48%, Чингис хаан музей-89%, Монгол алтайн хадны хамгаалалтын захиргаа-85%-тай нээлттэй мэдээлж, Чингис хааны өв соёлын хүрээлэн 3,57%, Уран зургийн галерей 7.14% хамгийн бага үнэлгээ авсан байна.

Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хэсэгт олонх байгууллагын үнэлгээ буурдаг. Тухайн хэсэгт оруулах мэдээлэл байгууллагын сайтад байгаа ч үнэлгээ хийх сайтад линкийг зөв холбоогүй эсвэл мэдээлэл оруулаагүй, оруулсан мэдээлэл бүрэн биш, хугацаа хоцорсон, эх сурвалжаа дурдаагүй зэрэг шалтгаантай.

6.3 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд

- Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл
- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт
- Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт
- Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл

Байгууллагуудын энэ бүлэгт байршуулсан мэдээллийн дундаж үнэлгээ **68.62%**-тай 5 бүлгээс хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Дүрслэх урлагийн музей-91.67%, Хархорум музей-91.29%, Байгалын түүхийн музей-87.5%-ийн үнэлгээ авч хамгийн бага үнэлгээтэй байгууллага нь Үндэсний урлагийн их театр-24.65%, Хүүхэд залуучуудын театр-15.63% байна.

Мэдээлэл оруулдаггүй оруулсан мэдээлэл нь шалгуур үзүүлэлт хангадаггүй заалт нь:

- Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт
- Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл юм.

Мөн энэ бүлгийн бүх заалт “Шилэн данс” цахим системтэй холбоотой байдаг бөгөөд байгууллагууд мэдээллээ нэвтрэх нууц үг нэхсэн байдлаар холбодог нь иргэдэд мэдээлэл авахад хүндрэлтэй бөгөөд нээлттэй мэдээллийн хүртээмжтэй байх гэсэн шалгуурыг хангахгүй байна.

6.4 Үзүүлж байгаа үйлчилгээ талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд

- Үйлчилгээний төрөл
- Төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл
- Шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар
- Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам
- Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл
- Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацааг нээлттэй мэдээлнэ.

Энэ бүлэгт байршуулсан мэдээллийн дундаж үнэлгээ **57.20** хувьтай үнэлэгдсэн.

Чингис хаан музей 100%, Улсын филармони 95.83% Соёлын өвийн үндэсний төв-93.06%-иар үнэлэгдсэн бол Хүүхдийн төв номын сан-0%, Чингис хааны өв соёлын хүрээлэн-0%, Үндэсний урлагийн их театр-9,72 хувийн үнэлгээтэй маш хангалтгүй байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой:

- Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам
- Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл
- Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацааг нээлттэй мэдээлээгүй байна.

6.5 Бусад мэдээллийг ил тод, нээлттэй байдалд

- Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа
- Бусад байгууллага, иргэнээс өгсөн санал
- Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт

Энэ бүлгийн үнэлгээ хамгийн бага буюу 43.89 хувь, Харьяа 5 байгууллага “0” оноо авсан байна. Үүнд: Хүүхэд залуучуудын театр, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн төв номын сан, Монголын үндэсний музей, Чингис хааны өв соёлын хүрээлэн

7. Үнэлгээ, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал;

Сайдын эрхлэх асуудлын хүрээний 26 харьяа байгууллагын “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох үнэлгээ хийх журам”-д заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд хэрэгжилт 55.4 хувьтай үнэлэгдэж өмнөх оны үнэлгээнээс 3 хувь буурсан дүнтэй байна..

Shilen gov.mn сайтад оруулсан тайлан мэдээ нь ил тод байдлыг хангаагүй бөгөөд мэдээлэл бүрэн бус үнэлгээний шалгуур хангахгүй, хавсаргасан нотлох баримт хангалтгүй түүнд тавих дотоод хяналт сул байна. Үнэлгээ буурсан шалтгаан нь зарим байгууллагын сайт, цахим хуудас ажилладаггүй, системд мэдээллийн линкийг холбоогүй эсвэл буруу холбосон, өөрт хамаарал бүхий мэдээллийг хамааралгүй тохиргоонд дураар шилжүүлэн “0” оноо авсан, байгууллагын мэдээллийн самбарыг хөтлөөгүй, шинэчлээгүй, самбар дахь мэдээллийн зураг оруулаагүй, бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн тухайгаа тайлагнаагүй, хугацаандаа нийтлээгүй, эх сурвалжийн тодорхой байдлыг дурдаагүй, оруулсан нотлох баримтууд албажаагүй зэрэг шалтгаантай байна.

Зөвлөмж 1. Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2-8.6-д заасан цаг үеийн болон төлөвлөгөөт үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, байгууллагын удирдлага иргэдийг хүлээн авч уулзах цагийн мэдээлэл, хүн, хуулийн этгээдээс гаргасан санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлтийн явцын мэдээлэл болон бусад мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол хяналт тавих;

Зөвлөмж 2. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бүрэн бүтэн, цаг хугацаандаа, тухайн мэдээллийг тодруулах, дэлгэрүүлж авах хүний нэр хаяг, эх сурвалж тодорхой байлгах, нотлох баримт нь албажсан pdf хэлбэрээр, шаардлага хангасан гэрэл зураг, мөн байгууллагын мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн хөтөлж зургаар баталгаажуулан оруулж байх;

Цаашид хяналт шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналтыг сайжруулан ажиллаж, танилцуулгаар хүргүүлсэн дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн 2026 оны хагас жилээр үр дүнг ахиулахыг Харьяа байгууллагын дарга захирал нарт чиглэл болгон хүргүүлж байна.

---oOo---

Харьяа байгууллагын Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ /Shilen gov.mn/

№	Байгууллагын нэр	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	Үнэлгээ I улирал
1	Соёл, урлагийн газар Агентлаг	87.04%	82.14%	77.27%	0.00%	80.56%	81.75%
2	Соёлын өвийн үндэсний төв	88.66%	93.48%	90.69%	93.06%	76.85%	88.55%
3	Кино урлагийн зөвлөл	74.54%	69.05%	87.50%	66.67%	62.92%	72.12%
4	Улсын драмын эрдмийн театр	42.89%	51.79%	86.81%	31.94%	41.67%	51.02%
5	Дуурь бүжгийн эрдмийн театр	47.30%	49.40%	52.21%	50.00%	45.83%	48.84%
6	Үндэсний урлагийн их театр	46.08%	42.86%	24.65%	9.72%	14.29%	51.00%
7	Улсын филармони	27.70%	22.62%	77.60%	95.83%	50%	54.75%
8	Хүүхэлдэйн театр	24.07%	13.89%	63.99%	58.33%	0%	32.05%
9	Хүүхэд залуучуудын театр	31.62%	46.43%	15.63%	29.17%	0%	46.43%
10	Монголын үндэсний номын сан	81.13%	82.64%	76.19%	87.50%	80.56%	81.60%
11	Хүүхдийн төв номын сан	29.40%	30.95%	69.64%	0%	0%	25.99%
12	Монголын Үндэсний музей	74.77%	78.57%	62.85%	87.50%	0%	60.73%
13	Чингис хаан үндэсний музей	78.24%	88.69%	85.42%	100%	77.08%	85.87%
14	Чойжин ламын сүм музей	44.81%	5.95%	55.06%	44.44%	1.67%	30.38%
15	Байгалийн түүхийн музей	74.66%	47.98%	87.50%	61.67%	51.39%	64.60%
16	Богд хааны ордон музей	42.13%	30.36%	87.15%	43.75%	31.67%	47.00%
17	Дүрслэх урлагийн музей	42.08%	51.79%	91.67%	62.50%	41.67%	57.08%
18	Театрын музей	62.36%	56.31%	58.33%	45.83%	12.50%	47.00%
19	Уран зургийн галерей	32.18%	7.14%	42.19%	80.56%	22.92%	36.98%
20	Хар хорум музей	66.22%	42.62%	91.29%	58.33%	29.17%	57.40%
21	Хөшөө цайдам музей	69.91%	49.40%	54.72%	83.33%	41.67%	59.80%
22	Чингис хааны өв соёлын хүрээлэн	9.72%	3.57%	38.01%	0%	0%	23.81%
23	Нүүдлийн соёл, иргэншлийг судлах ОУ хүрээлэн	62.71%	46.19%	86.81%	48.33%	66.25%	62.00%
24	Бурхан халдун уул, ТХТГ-ын хамгаалалтын захиргаа	68.75%	73.21%	45.31%	87.50%	80.53%	71.04%
25	Орхоны хөндийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа	77.31%	69.05%	86.36%	70.83%	66.67%	74.00%
26	Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа	82.41%	84.52%	89.17%	91.67%	0%	69.54%
	Дундаж үнэлгээ	56.49%	50.79%	68.62%	57.20%	43.89%	55.40%